

ӨРХИЙН БОЛОН БИЧИЛ ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ  
ХӨТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ БИЕЛЭЛТ

2023.12.15

Хүнс, хөдөө аж ахуйн газар

Зорилт	д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх он	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	2023 оны гүйцэтгэл
Зорилт - 1. Бизнес эрхлэгчдийн бүртгэлийн систем бий болгох, хөтөлбөрт хамрагдах өрхийн судалгаа гаргах, мэдээлэл хүргэх, хөтөлбөрт оролцогчдыг чадавхжуулах	1	Бизнес эрхлэгчдийн бүртгэлийн систем бий болгох, хөтөлбөрт хамрагдах өрхийн судалгааг тогтмол гаргах, мэдээллийг шинэчлэх, үр дүнг тайлагнах	2023-2026	Бүртгэлд хамрагдах бизнес эрхлэгчидийн тоо	1000	2500	<p>Орхон аймгийн нийт бизнес эрхлэгчдийг төвлөрсөн платформ системд байршуулах зорилгоор Смарт Эрдэнэт аппликейшны хөгжүүлэлт хийсэн. Энэхүү платформд 430 гаруй бизнес эрхлэгч бүртгэл хийлгэн баталгаажсан байна.</p> <p>Аймгийн хэмжээнд өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн судалгаа гарган бүртгэлжүүлж байна. Тайлант онд Баян-Өндөр сумын 26 багийн 1136 иргэн өрхийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа бөгөөд давхардсан тоогоор 391 иргэн, аж ахуйн нэгж аймгийн өрхийн болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгодог сан, сумдын Хоршоо хөгжүүлэх сан, Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн GIZ прогресс төсөл, АНУ-ын санхүүжилттэй Бест хөтөлбөр, Эх үүсвэртэй батлан даалтын сангийн хөнгөлөлттэй зээл, дэмжлэгт хамрагдсан</p> <p>Биелэлт 45.4 хувь</p>

	2	Хөтөлбөрт хамрагдах иргэдэд мэдээлэл хүргэх, өөрийн санаачлагаар хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй иргэдийг бүртгэх, судалгаа гаргах, сонгон шалгаруулах	2023-2026	Хөтөлбөрт хамрагдах өрх	50	Орхон аймгийн хөтөлбөрт хамрагдах иргэдэд мэдээлэл хүргэх зах зээлийн багтаамжийн судалгаа хийгдэж Эрдэнэт ШУТП-аас бизнес эрхлэх сонирхолтой, өөрийн санаачлагаар хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй 484 иргэдийг бүртгэн, бизнес эрхлэгч 307 иргэнд хөтөлбөрийн хүрээнд хүрч ажилласан. Төрийн байгууллагаас болон төсөл хөтөлбөрөөс олгогддог хөнгөлөлттэй зээл, дэмжлэгийн талаарх мэдээллийг иргэдэд хэвлэл мэдээллийн сувгаар нээлттэй хүргэж ажилласан. 2023 онд "Судлаач-Энтрепренер" хөтөлбөр хэрэгжүүлж инновацын төсөл, гарааны компани хөгжүүлэх 18 залуу судлаач, оюутны төсөл хүлээн авч, оролцогчдыг 2 сарын турш сургалтад хамруулан шилдэг оролцогч 2 оюутныг төслөө хэрэгжүүлэхэд ажлын байраар хангаж, 1 төсөлд нь 5.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. "Эрдэнэт цогцолбор" дээд сургуулийн 120 оюутны дунд гарааны бизнесийн уулзалт зохион байгуулж, гарааны бизнесийн хөтөлбөрт оролцох сонирхолтой 20 оюутны баг бүрдүүлэн зөвлөн ажиллаж байна. "Гарааны бизнес-2023" төслийн хүрээнд 33 өрхийн болон бичил үйлдвэрлэл эрхлэгчид тус бүр 5.0, хүнсний болон ногоон сууцны үйлдвэрлэлийн 3 төсөлд тус бүр 35.0,
--	---	---	-----------	-------------------------	----	---

					<p>нийт 270.0 сая төгрөгийг эргэн төлөх нөхцөлтэйгөөр олгохоор ажиллаж байна. Хүүхэд залуучуудад программ, код хөгжүүлэх сургалт явуулж буй “Код лаб” сургалтын төвд орон нутгийн төсвөөс 33.0 сая төгрөгийн өртөг бүхий 12 ширхэг зөөврийн компьютер олгосон бөгөөд тус сургалтын төвөөс 62 сурагчийг программ, код хөгжүүлэх сургалтад хамруулж чадавхжуулсан. Одоогийн байдлаар Эрдэнэт шинжлэх ухаан технологийн паркаас 17 гарааны бизнесийг дэмжин хөгжүүлээд байна.</p> <p>Биелэлт 100 хувь</p>
3	<p>Бизнес эрхлэх хандлагыг идэвхжүүлэх, бизнесийн анхан шатны мэдлэг олгох сургалт, арга хэмжээ зохион байгуулах</p>	2023-2026	<p>Сургалт, арга хэмжээнд хамрагдах иргэдийн тоо</p>	120	<p>Бизнес эрхлэх сонирхолтой иргэдэд анхан болон дунд шатны мэдлэг түгээх ажлын хүрээнд бизнесийн менежмент, борлуулалтын менежмент, брендинг үүсгэх, старт апп, бизнес загварыг хэрхэн тодорхойлох вэ сургалтыг нийт 794 иргэдэд түгээн хүрч ажилласан. Бизнес хөгжлийн төвд “Бизнес ширээ” ажиллуулж бизнес эрхлэх, татвар, тохирлын гэрчилгээ, хөнгөлөлттэй зээл болон хөрөнгө оруулалтын болом, оюуны өмчийг хамгаалах зэрэг 10 төрлийн мэдээллийг 250 гаруй иргэнд өгч анхан шатны мэдлэг олгосон. Өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг чадавхжуулах ажлын хүрээнд “Өрхийн бизнес модель гэж юуг хэлэх вэ, түүнийг хэрхэн ашиглах вэ?”, “Бизнес загвараа хэрхэн тодорхойлох вэ” сэдэвт 2 өдрийн</p>

					<p>сургалт зохион байгуулж Баян-Өндөр сумын 26 багийн 52 өрхийн үйлдвэрлэл эрхлэгч хамрагдаж өрхийн бизнес загвараа хэрхэн гаргах талаар мэдлэг, мэдээлэлтэй болж зөвлөх үйлчилгээнд хамрагдсан.</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны Хөдөлмөрт бэлтгэх суурь ур чадварын сургалтыг ХХҮЕГ-аас эрх авсан “Эм эс девелопмент консалтинг” ХХК-ны сургалтын төвтэй хамтарч өрхийн болон бичил бизнес эрхэлж байгаа 150 иргэнийг төсөл хэрхэн бичих, бизнесээ хөгжүүлэх сэдэвт 3 өдрийн сургалтад хамруулсан.</p> <p>Биелэлт 100 хувь</p>
4	Иргэдийг мэргэжил олгох сургалтанд хамруулах, ажлын байранд дадлагажуулах	2023-2026	Мэргэжил олгох сургалт, дадлагад хамрагдах иргэд	20	<p>Эрдэнэт ШУТП-аас нийт 480 иргэнийг мэргэжил олгох сургалтад хамруулан, Бизнес инкубатор төв дээр 120 иргэнийг ажлын байранд дадлагажуулсан. “Хөгжлийн шийдэл” Төрийн бус байгууллагын BEST хөтөлбөр нь бизнес эрхлэгчдэд зөвлөх үйлчилгээ үзүүлж төсөл бичих арга зүйд суралцуулан зээлийн ашиглалт, зарцуулалтын чиглэлээр сургалт өгснөөр хүнс, хувцас үйлдвэрлэл, газар тариалан болон бусад чиглэлээр 37 иргэн, аж ахуйн нэгж төсөл бичиж арилжааны банкнуудаас 1.9 тэрбум төгрөгийн бизнесийн зээл авч, 76 ажлын байр хадгалагдан, 6 ажлын байр шинээр нэмэгдсэн. Бялхам Ивээл ХХК-тай хамтран дэвшилтэт техник</p>

					<p>технологийг нэвтрүүлэх хүлэмжийн аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэдээллээр хангах замаар хүний нөөцийн чадавхыг сайжруулах “Хөдөө аж ахуй технологи” сэдэвт 2 өдрийн сургалтыг зохион байгуулж, хүлэмжийн аж ахуй эрхлэгч 45 иргэн хамрагдаж, хөрсний менежментийн технологи, суулгацын технологи, эрт тариалах технологи, усалгааны технологи, урьдчилсан сэргийлэх, халдварт өвчнөөс сэргийлэх технологи, улаан лооль, өргөст хэмх тариалах технологийн чиглэлийн мэдээлэлтэй болсон. Мөн Сэлэнгэ аймгийн Баруун хараад байрлах хүлэмжийн аж ахуйтай танилцаж, туршлага судлах ажлыг зохион байгуулсан. Хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийн хүнсний аюулгүй байдлын талаарх хууль эрхзүйн мэдлэг, салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах 1 сарын хөтөлбөрт сургалтыг Best хөтөлбөр, Обзерв Консалтинг хүнсний аюулгүй байдлын зөвлөх байгууллагатай хамтран зохион байгуулж, хүнсний боловсруулах 35 үйлдвэр, цехийг нийт 5 удаагийн сургалтад хамруулан мэдлэг олгон сертификат гардуулсан. Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоотой хамтран ОУХБ-ын “Бизнес эрхэлье” сургалтыг бизнес эрхлэх сонирхолтой хувиараа хөдөлмөр эрхлэгч болон албан бус салбарын нийт 60 залуучуудыг</p>
--	--	--	--	--	--

						хамруулж 2 өдөр зохион байгуулсан. Сургалтын зардалд нийт 4,8 сая төгрөг зарцуулсан. Биелэлт 100 хувь
Зорилт - 2. Санхүүжилт олгох, хөнгөлөлттэй нөхцөлөөр ажлын байраар хангах	5	Шаардлага хангасан бизнес эрхлэгчдэд тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт, эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн грант олгох	2023-2026	Санхүүжилт (грант буюу шагнал) авах бизнес эрхлэгчид	18	Засгийн газраас хэрэгжүүлж буй хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй зээлээс газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 17 иргэн 510.9 сая төгрөг, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч 1 иргэн 50.0 сая төгрөг, нийт 18 иргэн 560.9 сая төгрөг авсан. Аймгийн жижиг, дунд болон өрхийн үйлдвэр эрхлэгчдийн дэмжих тусгай сангаас 6 өрхийн бичил үйлдвэрлэл эрхлэгч ирэн, аж ахуйн нэгжид 274.0 сая төгрөгийн зээл олгогдсон. Баян-Өндөр сумын Хоршоог хөгжүүлэх сангаас 13 иргэнд 239.0 сая төгрөг, Жаргалант сумын хоршоо хөгжүүлэх сангаас 7 иргэнд 112.0 сая төгрөгийн зээл олгосон. Үйлдвэрлэгч баг төслийн хүрээнд үйлдвэрийн тоног төхөөрөмж 370 өрх, хүлэмж 90 өрх, Шинэ хөдөө төслийн хүрээнд үйлдвэрийн тоног төхөөрөмж 361 өрх, өрхийн үйлдвэрлэлийн дэмжих хөтөлбөрийн хүрээнд 23 өрхөд тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн. Эрдэнэт ШУТП-аас хүнсний ногооны үр үйлдвэрлэлийн төслийг инновацын төслөөр хөгжүүлэхээр зөвлөх үйлчилгээ үзүүлж,

					<p>"Баяжуулагч-Одод" ХХК-ийн хатаасан аарц, "Идэрбаялаг" ХХК-ийн давсалсан махны хатаамал зэрэг инновац шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжихэд тус бүр 6.0 сая, цаасны хог хаягдлаар эко түлш боловсруулах үйлдвэрлэл эрхэлж буй 1 компанид үйлдвэрлэсэн түлшээ нөөцлөхөд зориулж 20.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн. Мөн 11 өрхийн үйлдвэрлэл эрхлэгч нэгдэн хоршоо байгуулж мөөг ургуулах хөрс үйлдвэрлэж байна. Ингэснээр сард 500 кг мөөгийг ургуулах боломж бүрдүүлээд байна. Иргэн Зулчимэгийн амттаны үйлдвэрлэл, "Ган компас" ХХК-ийн экспортын тоглоом үйлдвэрлэл, "Мөөг кластер" ХХК-ийн чипс үйлдвэрлэл, тариалалтын ухаалаг чингэлэг үйлдвэрлэл, эмийн мөөг тариалалт, "Бидэрт манхан" ХХК-ийн хуванцар эдлэл үйлдвэрлэл, "БМОМ" ХХК-ийн биомасс боловсруулах зэрэг 9 төслийг дэмжин хөгжүүлж байна.</p> <p>Биелэлт 100 хувь</p>
6	Боломжит байршлуудад түрээсээр үйлдвэрлэл, үйлчилгээний ажлын байр бий болгох	2023-2026	Хөнгөлөлттэй нөхцөлөөр ажлын байр ашиглах бизнес эрхлэгчийн тоо		Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдэд байнгын үйл ажиллагаа явуулах, дотоод ажлаа тогтмолжуулахад тогтсон ажлын байр зайлшгүй шаардлагатай байдаг бөгөөд хүсэлт гаргасан үйлдвэрлэл эрхлэгчдийг ажлын байраар дэмжин ажиллаж байна.

						<p>30</p> <p>Үүнд: Яргуйт багийн хуучин байранд 2 иргэн түрээсийн гэрээгээр, Эрдэнэ багийн байр, Их залуу багийн өрхийн эмнэлэг, багийн байр, Баянцагаан, Говил багийн өрхийн эмнэлэгт 15 иргэн, аж ахуйн нэгж үйлдвэрлэл явуулах зорилгоор өмч ашиглалтын гэрээгээр ашиглаж байна.</p> <p>Эрдэнэт ШУТП-ийн Бизнес инкубатор төвд 4 аж ахуйн нэгж бойжиж будаг үйлдвэрлэх, электрод үйлдвэрлэх, мөөгний субстрат бэлдэх үйлдвэрлэл, барилгын материалын хуурай хольц үйлдвэрлэл эрхлэх чиглэлийн үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>Биелэлт 70 хувь</p>
Зорилт - 3. Бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх	7	Смарт Эрдэнэт платформын "Эрдэнэтийн брэнд" цахим системээр хувийн хэвшилтэй хамтран бүтээгдэхүүн худалдаалах	2023-2024	Смарт Эрдэнэт платформын "Эрдэнэтийн брэнд" цахим системийн харилцагчид	-	<p>"Смарт Эрдэнэт" аппликейшний онцлог нь E-Mongolia буюу төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системийн дэд систем байдлаар орон нутгийн бүхий л үйлчилгээг нэг дор багтаасан цахим платформ юм. Иргэд энэхүү аппликэйшнээс орон нутгийн төр захиргааны байгууллагаас гарч буй шийдвэр, үйл ажиллагаа, мэдээ мэдээллийг авахын зэрэгцээ орон нутгийнхаа 10 мянган бизнес эрхлэгчдэдээ зориулж бизнесийн категори тус бүрээр нь ангилан өөрийн бизнес харилцагч, хэрэглэгчдийнхээ хүрээг тэлэх боломжийг олгож байна. Смарт Эрдэнэт аппликейшн нь Төр-Иргэн-бизнес эрхлэгч болон үйлчилгээний байгууллагын төвлөрсөн</p>



					<p>платформ. 2023 онд 1820 хэрэглэгч утсандаа татаж суулгаснаас, платформыг 738 иргэн идэвхтэй хэрэглэдэг. Нийт 315 бизнес эрхлэгч хаяг байршил, утасны дугаар, үйл ажиллагааны зургаа байршуулсан. Өдөр тутам орхон аймгийн шинэ соргог мэдээ мэдээллийг тус аппликейшнаар дамжуулах авахаас гадна үйлчилгээний байгууллагуудад оочир дараалал үүсгэлгүй цаг аван үйлчлүүлэх боломж нөхцөлөөр хангаж өгөв. Эрдэнэтийн брэнд бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэхийн тулд Эрдэнэт ШУТП нь 5-7а байрны Б1 давхарт хүргэлтийн үйлчилгээг хэрэглээ болгох, хялбараар асуудлыг шийдэх, бизнес эрхлэгчдийн борлуулалтыг дэмжин өсгөх зорилгоор зориулалтын агуулах гаргасан.</p> <p>Биелэлт 100 хувь</p>
8	<p>Бизнесийн дунд шат, оюуны өмч, брэндийн зөвлөх үйлчилгээ, улс, орон нутгийн түвшинд хэрэгжүүлж буй бусад төсөл, хөтөлбөрүүдэд хамрагдахад дэмжлэг үзүүлэх</p>	2023-2026	төсөл, хөтөлбөрт хамрагдсан бизнес	20	<p>Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэлтийг дэмжих PROGRESS төсөлтэй хамтран жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд “Брэндийг хэрхэн бүтээх вэ?” сэдвээр сургалт зохион байгуулж, сургалтад 25 аж ахуйн нэгж хамруулсан. Энэхүү сургалтын үр дүн дээр тулгуурлан брэнд бүтээгдэхүүний шалгуур хангахуйц 8 аж ахуйн нэгжид ганцаарчилсан зөвлөх үйлчилгээг үзүүлж ажилласан. “Egan Brand consulting”-н зөвлөх багшийг урьж Орхон аймагт аль төрлийн</p>

			эрхлэгчийн тоо		<p>брэнд бүтээгдэхүүн бий болгож нутагшуулах талаар сургалт зохион байгуулж, уулзалт, хэлэлцүүлэг хийсэн.</p> <p>Орон нутгийн онцлог бүтээгдэхүүний бэлгийн багц гаргах зорилгоор багцад оруулах бүтээгдэхүүнийг шалгаруулах болзолт уралдаан зарласан ба шалгаруулалтыг 12 сард багтаан зохион байгуулна.</p> <p>Биелэлт 100 хувь</p>
9	Дотоод, гадаадын үзэсгэлэн худалдаа, туршлага судлах болон бусад уралдаан, арга хэмжээнд оролцуулах	2023-2026	Үзэсгэлэн худалдаа, арга хэмжээнд оролцогчийн тоо	100	<p>“Эрдэнэтэд үйлдвэрлэв-2023” үзэсгэлэн худалдаа 2023 оны 11 сарын 15-17 өдрүүдэд Хангарьд паласт зохион байгуулагдаж хүнс, шазар тариалан, сүлжмэл, оёдол, гар урлалын салбарын орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгч 54 иргэн, аж ахуйн нэгж өөрсдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээр оролцож 27.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Үзэсгэлэн худалдаанд оролцогчдоос 9 номинацид 12 бүтээгдэхүүн шалгаруулж урамшуулсан.</p> <p>Аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхимаас зохион байгуулсан хавар, намрын үзэсгэлэн худалдаанд 3 асар түрээслэн авч хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг болон жижиг зээл авсан нийт 21 иргэний үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг борлуулж 14,0 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. Үзэсгэлэн худалдааны түрээсийн төлбөрт 1,8 сая төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулсан.</p> <p>“Цах маркет” худалдааны төвд “Эрдэнэтэд үйлдвэрлэв”, Их залуу багт байрлах “Билэг”</p>

						худалдааны төвд тус тус борлуулалтын цэгийг нээн ажиллуулж, түрээсийн төлбөрт 11,8 сая төгрөг зарцуулсан. Борлуулалтын цэгээр 44 иргэний 18 нэр төрлийн бүтээгдэхүүн тавигдаж 26,8 сая төгрөгийн борлуулалт хийгдэж байнгын 2 ажлын байр бий болсон байна. Давхардсан тоогоор ний 119 иргэнийг оролцуулж ажиллаа. Биелэлт 90 хувь
10	Аялал жуулчлалын дамжин өнгөрөх зам дагуу "Эрдэнэтийн брэнд" дэлгүүр байгуулах	2023	"Эрдэнэтийн брэнд" дэлгүүрийн харилцагчийн тоо		27	"Эрдэнэтэд үйлдвэрлэв" төвийг Цагаанчулуут багт 1500 мкв газарт байгуулахаар зураг төсөл боловсруулах даалгавар боловсруулж, Орон нутгийн өмчийн газраас тендер зарлаад байна. Тус төв нь худалдаа үйлчилгээний зориулалттай, зоорьтой, зоорины давхарт хүнсний ногоо, бараа материал түр хадгалах агуулахтай, 1 дүгээр давхартаа худалдааны танхим, нийтийн ариун цэврийн өрөө, цайны газар, 2 дугаар давхарт сургалт, үйлдвэрлэл, ажлын болон ариун цэврийн өрөө байхаар төлөвлөгдсөн. Тус ажлыг гүйцэтгэхэд орон нутгийн төсөвт хөрөнгө тусган ажиллаж байна. Биелэлт 30%
Биелэлтийн дундаж, хувь						83.54 хувь

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:  
 ҮЙЛДВЭР, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ДАРГА, ХУДАЛДААНЫ АСУУДАЛ  
 ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Г.БАТДЭЛГЭР

